



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/33

Маңдалговь


Эмчилгээний бэлэн хоол хуваарилах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 24 дүгээр зүйлийн 24.6.10, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Эмчилгээний сүү, бэлэн хоолыг орлогод авч, хуваарилах тухай" А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн 3,464,800 (гурван сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга найман зуун) төгрөгийн 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний бэлэн хоолны хуваарийг хавсралтаар баталсугай.


2.Хуваарилагдсан эмчилгээний бэлэн хоолыг холбогдох журам, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн хөрөнгийн бүртгэлд авч, зарцуулалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (Б.Ширчмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНТӨГС

9034064 X 4816129119

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн
А/33 дугаар тушаалын хавсралт



ЭМЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН ХООЛНЫ ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	RUTE эмчилгээний бэлэн хоол, ууттай 92g(Нэг хайрцагт 150 ширхэг)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Адаацаг	1	173,240	173,240
2	Баянжаргал	1	173,240	173,240
3	Говь-Угтаал	1	173,240	173,240
4	Гурвансайхан	1	173,240	173,240
5	Дэрэн	1	173,240	173,240
6	Дэлгэрхангай	1	173,240	173,240
7	Дэлгэрцогт	1	173,240	173,240
8	Луус	1	173,240	173,240
9	Өлзийт	1	173,240	173,240
10	Өндөршил	1	173,240	173,240
11	Сайхан-Овоо	1	173,240	173,240
12	Цагаандэлгэр	1	173,240	173,240
13	Хулд	1	173,240	173,240
14	Эрдэнэдалай	2	173,240	346,480
15	Сайнцагаан	2	173,240	346,480
16	БМӨЭМТ	1	173,240	173,240
17	ӨМӨЭМТ	2	173,240	346,480
	Нийт	20		3,464,800